



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/743.

Булган сум

Г Гадаад томилолтод хөрөнгө гаргах тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны II/04 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн 3.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын Зүүн Хойд Бүсийн төв, Дэлхийн боловсролын сургалтын төвөөс 2023 оны 11 дүгээр сарын 12 - 17-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчеон хотод “Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийг сайжруулах үйл ажиллагааг тусгаж хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтад оролцох албан хаагчдын нэрсийг 1 дүгээр, шаардагдах хөрөнгийн тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Гадаад албан томилолтод шаардагдах 14.824.080 (арван дөрвөн сая найман зуун хорин дөрвөн мянга ная) төгрөгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010855

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11.. дугаар сарын 02-ны өдрийн  
А/743 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**“ОРОН НУТГИЙН ГАМШГИЙН ЭСРДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТӨД УУР  
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТУСГАЖ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТАД ОРОЛЦОХ АЛБАН АЛБАН  
ТУШААЛТАН**

Гамшгийн эрсдэлийг бууруулах  
Орон нутгийн зөвлөлийн гишүүд:

- Ч.Энхбаяр (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
- Б.Одхүү: (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гамшгийн эрсдэлийг бууруулах  
Орон нутгийн зөвлөлийн нарийн бичгийн дарга:

- Д.Ууганбаяр (аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа )

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11 дугаар сарын 02-ны өдрийн  
А/743 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**“ОРОН НУТГИЙН ГАМШГИЙН ЭСРДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨЛТӨД  
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ТУСГАЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТАД ОРОЛЦОХ АРГА  
ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр	1 хүний зардал /төгрөгөөр/	3 хүний зардал /төгрөгөөр/
1	Улаанбаатар -Инчеон- Улаанбаатар нислэгийн тийз	1.492.600	4.477.800
2	Томилолт зам, хоногийн зардал 2023.10.29-ний өдрийн Монгол банкны ханш 3448.76 төгрөг /Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал/	689.752x5 хоног 3.448.760	10.346.280
	<b>Нийт дүн</b>	<b>4.941.360</b>	<b>14.824.080</b>